



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/368

Арвайхээр

**Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах
дуудлага худалдааг зохион байгуулах ажлын
хэсэг томилох, үнэ тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.д, 29.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9.1, 9.2 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5, 13 дугаар багийн нутаг дэвсгэрт 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай 1 нэгж талбар, үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газрын зориулалттай 5 нэгж талбар, худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 1 нэгж талбар, нийт 7 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Т.Ариунболд (Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Дуудлага худалдааны хөтлөгч: Э.Хорлоо (Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Ц.Майнбаяр (Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Ч.Бат-Өлзий (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Газар, байгаль орчин, аялал жуулчлалын бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Г.Ариунаа (Аймгийн Засаг даргын дэргэдэх Өмчийн хэлтсийн мэргэжилтэн)

2. Комиссын дарга (Т.Ариунболд)-д ДААЛГАХ нь:

а. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны өсгөн хэлэх үнийн доод, дээд хязгаарыг хавсралтаар баталж, зохих журмын дагуу дуудлага худалдааг зохион байгуулах.

б. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100787

Аймгийн Засаг даргын 2021 оны 07
 дугаар сарын 21-ны өдрийн 1/36 дүгээр
 захирамжийн хавсралт

АРВАЙХЭЭР СУМЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ
 БҮХИЙ ГАЗАРТ ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА
 ХУДАЛДААНЫ ӨСГӨХ ҮНИЙН ДООД, ДЭЭД ХЯЗГААР

№	Төлөвлөж буй газрын байршил	Төлөвлөлт ийн нэгж талбарын дугаар	Газар эзэмшүүлэх Зориулалт	Эзэмш үүлэх газрын хэмжээ /м2/	Газар эзэмших эрхийн гэрчилгээ ний дуудлага худалдаа ны анхны үнэ (мян.төг)	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны өсгөн үнэ	
						Доод үнийн хязгаар /мян.төг/	Дээд үнийн хязгаар /мян.төг/
1.	Онги 13 дугаар баг, шинэ Арвайхээр төв	2266835	5-8 давхар нийтийн орон сууц	4335	15606,0	1000,0	5000,0
2.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2252603	Үйлдвэрлэл ийн барилга байгууламж, бусад газар	4360	10464,0	1000,0	5000,0
3.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2252604	Үйлдвэрлэл ийн барилга байгууламж, бусад газар	7276	17462,4	1000,0	5000,0
4.	Онги 13 дугаар баг, шинэ Арвайхээр төв	2252606	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	1403	5050,3	500,0	1000,0
5.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264134	Үйлдвэрлэл ийн барилга байгууламж, бусад газар	10000	24000,0	1000,0	5000,0
6.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264135	Үйлдвэрлэл ийн барилга байгууламж, бусад газар	10000	24000,0	1000,0	5000,0
7.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264136	Үйлдвэрлэл ийн барилга байгууламж, бусад газар	10000	24000,0	1000,0	5000,0